



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/190

Ховд

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр, “Үйлдвэрлэгч Ховд” аймгийн дэд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ховд аймгийн Жаргалант суманд уламжлалт аргаар мал нядлах, боловсруулах зориулалттай, мал нядлах цехтэй нэгдсэн малын захыг 100 хувийн өөрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах хүсэлтээ ирүүлсэн “Мөнх гэгээн Жаргалант” ХХК-д аймгийн үйлдвэрийн бүсэд байршилтай өөрийн эзэмшлийн 1,0 га газарт мал нядлах, боловсруулах зориулалттай захыг барьж байгуулах зөвшөөрлийг олгосугай.

2. Тус компанийн үйл ажиллагааг дэмжиж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Бямбажав/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ